



**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
ТЭЭВРИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ**

2017 оны 02 сарын 15 өдөр

Дугаар А/22

Улаанбаатар хот

┌ Тэргүүний байгууллага, хөдөлмөрийн  
аварга шалгаруулах тухай ┐

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2016 оны А/928 дугаар захирамжаар батлагдсан “Нийслэлийн тээврийн газрын дүрэм”-ийн 2.5.3 дахь заалт, тус газрын даргын 2011 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 09 дүгээр тушаалаар батлагдсан “Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний тэргүүний аж ахуйн нэгж, байгууллага, хөдөлмөрийн аварга шалгаруулах журам”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын захиргааны зөвлөлийн гишүүдийн 2017 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн хурлаар нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудаас ирүүлсэн хүсэлтийг хэлэлцэн шийдвэрлэсний дагуу дээрх журамд заасан шагналуудад дараах байгууллага, албан тушаалтныг шалгаруулсугай. Үүнд:

“Тэргүүний байгууллага”

Эрдэм транс ХХК

Вип такси сервис ХХК

“Хөдөлмөрийн аварга инженер  
техникийн ажилтан”

НЧБ ХХК-ийн дэд захирал Д.Нармандах

Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ-ын  
инженер Б.Баатарцогт

“Хөдөлмөрийн аварга жолооч”

Сутайнбуянт ХХК-ийн жолооч Т.Насанбат

Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ-ын  
жолооч М.Занданмядаг

Вип такси сервис ХХК-ийн жолооч М.Бямбаа

“Хөдөлмөрийн аварга шалгагч”

Блюбус ХХК-ийн шалгагч Н.Цэрэнханд

“Хөдөлмөрийн аварга засварчин” Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ-ын засварчин Ж.Батсүрэн

Тэнүүн огоо ХХК-ийн засварчин С.Дашбалдан

2. “Тэргүүний байгууллага”-ыг “Өргөмжлөл”, 500000 / таван зуун мянган/, “Хөдөлмөрийн аварга”-ыг “Өргөмжлөл”, 200000 / хоёр зуун мянган / төгрөгөөр тус тус шагнаж, өргөмжлөл хийлгэх зардал болон мөнгөн шагналыг дотоод эх үүсвэрээсээ санхүүжүүлэхийг тухайн байгууллага, аж ахуйн нэгжийн захирал нарт даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг орлогч даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч / Х.Булгаа /-д үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.ОТГОНБААТАР